

“ЦАХИМ ДАНС” СИСТЕМ

Стандарт инвестмент ҮЦК-ийн харилцагч та манай “Цахим данс” системд дорх зааврын дагуу бүртгүүлнэ үү.

1. <https://dbx.standardinvestment.mn/> хаягаар нэвтэрч орно.
2. “Бүртгүүлэх” товчин дээр дарж орсны дараа регистрийн дугаар (*зөвхөн кирилл үсгээр*), и-мэйл хаяг, нууц үгээ хийнэ.
3. Үйлчилгээний нөхцлийг уншиж танилцаад, “Бүртгүүлэх” товчийг дарна.
4. Таны бүртгүүлсэн и-мэйл рүү бүртгэлээ идэвхжүүлэх тухай и-мэйл очно. Та “энд” гэдэг үгэн дээр дарсны дараа таны бүртгэл идэвхжинэ.
5. Та бүртгүүлсэн и-мэйл, нууц үгээ оруулан дахин нэвтэрч, аль нэг арилжааны банкин дахь өөрийн нэрийн дансны дугаар, утасны дугаар, иргэний үнэмлэхний (*ар өвөргүй*), хүүхэд бол төрсний гэрчилгээний зургийг хавсарган, бусад мэдээллийг бөглөсний дараа “илгээх” товчийг дарна.
6. Үүний дараа Стандарт инвестмент ҮЦК-аас таны илгээсэн мэдээллийг нягтлан, ажлын нэг өдрийн дотор баталгаажуулна.
7. Ийнхүү баталгаажуулсны дараа та манай “Цахим данс” системийг хэрэглэхэд бэлэн болно. Та “Цахим данс” системээр:
 - Хувьцааны данс, мөнгөний үлдэгдлээ хянана;
 - Дансны хуулга, арилжааны гүйлгээгээ харна;
 - Захиалгаа онлайн өгнө;
 - Авсан хувьцааныхаа өгөөж/алдагдлын тооцооллыг харна;
 - Багц үүсгэж, тус бүрт нь хянах боломжтой.

Стандарт инвестмент ҮЦК-ийн “Цахим данс” үйлчилгээний нөхцөл:

1. Харилцагч өөрийн и-мэйл хаяг болон бусад хувийн мэдээллийг үнэн зөв, бүрэн бөглөнө.
2. Харилцагчийн “Цахим данс” системд өөрийн бүртгүүлсэн нэвтрэх нэр, нууц үгийг ашиглан оруулсан холбогдох хүсэлт, үнэт цаас худалдах, худалдан авах захиалга, мөнгө хүсэх өргөдөл нь харилцагч өөрийн биеэр ирж гарын үсэг зурсан, санхүүгийн болон бусад тамга, тэмдэг дарсантай нэгэн адил хүчинтэйд тооцогдоно.
3. Цахим үйлчилгээг авах арга хэрэгсэл, үйлчилгээг авахтай холбоотой Стандарт инвестмент ҮЦК-аас өгсөн заавар, өөрийн нууц код, хэрэглэгчийн нэр, нууц үг болон цахим шуудан, гар утсаар хүлээн авсан мэдээлэл зэргийг бусдад алдсан, ашиглуулсан, эсхүл тийнхүү ашиглуулах боломж олгосноос үүссэн үр дагаврыг харилцагч бүрэн хариуцна.
4. “Цахим данс” системд бүртгүүлж, цахим үйлчилгээ авахын тулд харилцагч идэвхтэй и-мэйл хаягаар бүртгүүлэх шаардлагатай. Бүртгүүлсэн и-мэйл хаягаар захиалгын биелэлт, дансны хуулга болон үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээллийг харилцагчид мэдэгдэх тул и-мэйл хаягийг цаашид солихгүй байна.
5. Та өөрийн нэвтрэх эрх, дансны аюулгүй байдлаа хамгаалахын тулд дараах зүйлсийг анхаарахыг зөвлөж байна. Үүнд:
 - a. Нэвтрэх эрхийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үүднээс өөрийн данс руу компьютер, таблет болон бусад мобайл төхөөрөмж зэрэг олон төхөөрөмжөөс хандахгүй байх;
 - b. Мөн дээрх төхөөрөмжүүдээс нэвтрэхдээ нэвтрэх хаяг, нууц үгээ сануулахгүй байх;
 - c. Өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй, ашиглуулахгүй байх.